



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 212

Улаанбаатар хот

“Баянгол зочид буудал” ХК-ийн үнэт цаасны
бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Компанийн тухай хуулийн 32.4, 31.2.1, “Баянгол зочид буудал” ХК-ийн 2012 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 3 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Баянгол зочид буудал” ХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 323,065 /гурван зуун хорин гурван мянга жаран тав/ ширхэг хувьцаа, нэг бүр нь 255 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 17,100 /арван долоон мянга нэг зуу/ ширхэг энгийн хувьцаа болон нэг бүр нь 220 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 82,900 /наян хоёр мянга есөн зуу/ ширхэг энгийн хувьцааг тус тус нэг бүрийг нь 130 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 423,065 /дөрвөн зуун хорин гурван мянга жаран тав/ ширхэг энгийн хувьцаанд хөрвүүлж үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Саруул/, хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Баянгол зочид буудал” ХК /Х.Цэндбаяр/-д үүрэг болгосугай:

1/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

2/ Хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ийг мөрдөж ажиллах;

3/ Энэхүү тогтоолын 1, 2-т заасан өөрчлөлтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, өөрчлөлтийг тэмдэглүүлэн Хороонд ажлын 10 хоногийн дотор ирүүлэх;

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



001619